



МОНГОЛ УЛС
ХЭНГИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 03 сарын 14 өдөр

Дугаар 01/100

Хэрлэн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.4, 58.2.17 Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт зарцуулалтын журмын 2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн эрүү иргэний давж заалдах шатны шүүхийн шүүгч Б.Сүхгомбо, Зооноз өвчин судлалын төвийн дарга Г.Наранхүү нар нь Төрийн дээд шагнал "Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон" медалиар тус тус шагнагдсан тул хүндэтгэл үзүүлж, хөрөнгө зарцуулсугай.

2. Шаардагдах зардлыг хавсралтаар баталсугай.

3. Дээрх зардлын 783200 /Долоон зуун наян гурван мянган хоёр зуун/ төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн болзошгүй зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Санхүү, төрийн сангийн хэлтэс /С.Нямдаваа/-т, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар /Ж.Ганбаатар/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

03 Аймгийн Засаг даргын 2017 оны
..... дугаар сарын..... өдрийн
дугаар захирамжийн хавсралт



ЗАРДЛЫН ТООЦОО

№	Зардлын нэр	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Бүгд үнэ
1	Мөнгөн аяга	2	161600	323200
2	Аяганы бичвэр	2	10000	20000
3	Зураг	2	180000	360000
4	Ааруул	2	12000	24000
	Дүн			783200